

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. Аудитын тайлан.....	16
3.1. Ерөнхий зүйл.....	16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	17
3.4. Материаллаг байдал.....	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт	20
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/541
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Консерваторийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Байгууллагын соёлыг дээшлүүлж, таатай орчин бүрдүүлэх" зорилтын хүрээнд зургаан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,588,500.00	2,606,100.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	17,600.00
31110	Төгрөг	0.00	17,600.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,588,500.00	2,588,500.00
31210	Төгрөг	2,588,500.00	2,588,500.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,588,500.00	2,588,500.00
33	АВЛАГА	0.00	904,080.00
33500	Бусад авлага	0.00	904,080.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	904,080.00
35	БАРАА МАТЕРИАЛ	168,101,596.90	222,065,402.90
35100	Түүхий эд материал	16,465,085.00	17,032,538.00
35110	Тусгай зориулалттай материал	16,285,394.00	16,285,394.00
35130	Эм боох материал	179,691.00	747,144.00
35400	Хангамжийн материал	151,636,511.90	205,032,864.90
35410	Бичиг хэргийн материал	5,929,100.00	4,906,795.00
35420	Аж ахуйн материал	110,994,537.90	149,739,030.90
35430	Сэлбэг хэрэгсэл	43,000.00	43,000.00
35440	Түлш, шатах тослох материал	26,180.00	1,660,000.00
35450	Барилгын засварын материал	756,300.00	10,012,850.00
35470	Бусад хангамжийн материал	33,887,394.00	38,671,189.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>170,690,096.90</u>	<u>225,575,582.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,255,814,212.11	10,868,330,821.18
39200	Биет хөрөнгө	10,420,092,478.91	10,034,538,060.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,503,526,410.85	9,503,526,410.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276,073,912.44)	(529,141,665.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,400,000.00	47,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,159,999.64)	(15,504,999.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,083,903,679.35	2,139,506,690.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,250,731,714.38)	(1,380,649,729.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	709,654,747.31	675,622,695.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(518,036,449.42)	(545,197,776.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,952,942.40	27,867,942.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,941,942.44)	(21,977,525.81)
39217	Ном	130,598,717.32	133,086,017.32
39300	Биет бус хөрөнгө	835,721,733.20	833,792,760.88
39301	Програм хангамж	16,764,000.00	16,064,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,084,666.80)	(7,313,639.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	825,042,400.00	825,042,400.00

II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,255,814,212.11</u>	<u>10,868,330,821.18</u>
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,426,504,309.01</u>	<u>11,093,906,404.08</u>
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	671,422.85	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	671,422.85	0.00
41300	Өглөг	671,422.85	0.00
41360	Бусад өглөг	671,422.85	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	671,422.85	0.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,425,832,886.16</u>	<u>11,093,906,404.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,010,432,655.62	8,010,432,655.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,010,432,655.62	8,010,432,655.62
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,710,162,657.37)	(2,042,089,139.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,710,162,657.37)	(1,710,162,657.37)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(331,926,482.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,125,562,887.91	5,125,562,887.91
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,426,504,309.01</u>	<u>11,093,906,404.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	4,527,623,724.00	4,722,774,375.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,527,623,724.00	4,722,774,375.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	485,307,624.00	336,055,475.00
120	Нийтлэг татварын бус орлого	445,838,724.00	296,332,999.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	445,838,724.00	296,332,999.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	408,221,285.00	228,357,420.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,603,050.00	25,792,090.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	15,014,389.00	42,183,489.00
122	Тусламжийн орлого	39,468,900.00	39,722,476.00
122001	Хандив тусламж /дотоод	39,468,900.00	39,722,476.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,042,316,100.00	4,386,718,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,918,526,100.00	4,380,500,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,918,526,100.00	4,380,500,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,790,000.00	6,218,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,000,000.00
131104	Нэмэлт санхүүжилт	11,086,000.00	260,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	112,704,000.00	958,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,874,914,561.87	5,054,700,857.08
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,874,914,561.87	5,054,700,857.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,874,914,561.87	5,054,700,857.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,674,599,079.19	4,257,802,363.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,197,504,972.09	3,242,454,375.20
210101	Үндсэн цалин	1,635,490,247.16	1,717,996,067.41
210102	Нэмэгдэл	1,477,960,924.93	1,420,935,822.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,053,800.00	54,550,400.00
210104	Урамшуулал	0.00	48,972,085.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	390,978,801.09	190,889,237.68
210201	Тэтгэврийн даатгал	276,065,319.37	70,092,974.85
210202	Тэтгэмжийн даатгал	26,285,476.39	56,844,977.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,020,846.06	8,125,173.68
210204	Ажилгүйдлийн даатгал	5,017,793.86	1,279,200.65
210205	Эрүүл мэндийн даатгал	51,589,365.41	54,546,911.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,673,660.99	138,152,885.31
210301	Гэрэл, цахилгаан	55,051,505.00	41,273,318.00
210302	Түлш, халаалт	80,888,670.26	67,907,356.31

Монгол Улсын консерваторийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	27,733,485.73	13,972,211.00
210304	Байрны түрээс	140,000,000.00	15,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,918,652.00	52,265,586.00
210401	Бичиг хэрэг	11,826,380.00	8,336,960.00
210402	Тээвэр, шатахуун	2,230,136.00	2,908,128.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,183,900.00	8,028,797.00
210404	Ном, хэвлэл	560,200.00	384,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,244,400.00	12,776,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,827,030.00	838,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	24,046,606.00	18,992,701.00
2105	Нормативт зардал	47,803,844.00	37,895,622.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,644.00	195,447.00
210502	Хоол, хүнс	47,688,200.00	37,071,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	629,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,004,200.00	11,543,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	299,900.00
210604	Урсгал засвар	8,804,200.00	11,243,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,217,280.00	114,035,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	103,247,200.00	90,520,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	15,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,580.00	143,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,235,500.00	8,372,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	547,497,669.02	470,565,526.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,274,100.00	1,181,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,139,674.00	13,307,410.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	488,083,895.02	456,076,666.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,315,482.68	796,898,493.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	169,123,812.00	230,817,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,731,200.00	10,530,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,986,612.00	198,012,260.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,406,000.00	22,275,440.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,770,850.68	566,022,093.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,770,850.68	566,022,093.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	420,820.00	58,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,820.00	58,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(347,290,837.87)	331,926,482.08)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(347,290,837.87)	(331,926,482.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,474,512,006.00	4,640,868,410.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	430,824,335.00	254,149,510.00
120	Нийтлэг татварын бус орлого	430,824,335.00	254,149,510.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	430,824,335.00	254,149,510.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	408,221,285.00	228,357,420.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,603,050.00	25,792,090.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,043,687,671.00	4,386,718,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,918,526,100.00	4,380,500,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,918,526,100.00	4,380,500,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,790,000.00	6,218,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	900,000.00
131104	Нэмэгдэл санхүүжилт	11,086,000.00	260,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	112,704,000.00	58,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,371,571.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,371,571.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,400,416,316.00	4,611,980,010.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,400,416,316.00	4,611,980,010.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,200,100,833.32	3,815,081,516.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,198,406,370.24	3,267,313,132.39
210101	Үндсэн цалин	2,283,631,471.00	2,267,363,752.80
210102	Нэмэгдэл	809,784,899.24	924,733,594.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,190,000.00	56,425,307.40
210104	Урамшуулал	24,800,000.00	18,790,477.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	390,978,801.09	167,182,733.34
210201	Тэтгэврийн даатгал	390,978,801.09	137,145,894.63
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	168,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	30,240.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	7,560.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	29,831,038.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,673,660.99	138,152,885.31
210301	Гэрэл, цахилгаан	55,051,505.00	41,273,318.00
210302	Түлш, халаалт	80,888,670.26	67,907,356.31

Монгол Улсын консерваторийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	27,733,485.73	13,972,211.00
210304	Байрны түрээс	140,000,000.00	15,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,269,916.00	41,978,850.00
210401	Бичиг хэрэг	10,501,980.00	4,565,555.00
210402	Тээвэр, шатахуун	2,230,136.00	4,046,048.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,723,800.00	8,692,897.00
210404	Ном, хэвлэл	569,950.00	517,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,244,400.00	12,776,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,999,650.00	11,381,200.00
2105	Нормативт зардал	57,774,535.00	39,822,275.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	145,335.00	2,122,100.00
210502	Хоол, хүнс	47,688,200.00	37,071,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,941,000.00	629,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,293,696.00	23,628,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	293,700.00	2,303,700.00
210602	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	825,000.00
210604	Урсгал засвар	24,999,996.00	20,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	128,740,980.00	114,035,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,539,500.00	90,520,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	15,000,000.00
210803	Тээврийн хэрэгслийн татвар	331,480.00	143,100.00
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,370,000.00	8,372,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,962,874.00	22,967,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,462,900.00	1,833,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,499,974.00	21,133,710.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,315,482.68	796,898,493.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	169,123,812.00	230,817,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,731,200.00	10,380,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,986,612.00	214,667,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,406,000.00	5,770,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,770,850.68	566,022,093.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,770,850.68	566,022,093.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	420,820.00	58,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,820.00	58,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	74,095,690.00	28,888,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	71,842,110.00	28,870,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,842,110.00	28,870,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,842,110.00	28,870,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,842,110.00	28,870,800.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(71,842,110.00)	(28,870,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,253,580.00	17,600.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	334,920.00	2,588,500.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,588,500.00	2,606,100.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(1,362,871,819.50)	11,773,123,724.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(347,290,837.87)	(347,290,837.87)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(1,710,162,657.37)	11,425,832,886.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(331,926,482.08)	(331,926,482.08)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(2,042,089,139.45)	11,093,906,404.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>	5,042,849,000.00	4,068,610,216.04	974,238,783.96	80.6
II	<u>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</u>	5,042,849,000.00	4,068,610,216.04	974,238,783.96	80.6
21	<u>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</u>	4,571,857,700.00	3,838,692,316.04	733,165,383.96	83.9
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>	580,632,500.00	404,456,450.31	176,176,049.69	69.6
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</u>	3,618,145,600.00	3,267,053,132.39	351,092,467.61	90.3
210101	Үндсэн цалин	2,251,914,300.00	2,267,363,752.80	(15,449,452.80)	100.6
210102	Нэмэгдэл цалин	1,266,041,300.00	924,733,594.48	341,307,705.52	73.0
210103	Унаа хоолны нэмэгдэл	80,190,000.00	56,165,307.40	24,024,692.60	70.0
210104	Урамшуулал	20,000,000.00	18,790,477.71	1,209,522.29	93.9
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</u>	373,079,600.00	167,182,733.34	205,896,866.66	44.8
210201	Тэтгэврийн даатгал	297,289,400.00	137,145,894.63	160,143,505.37	46.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,898,000.00	168,000.00	5,730,000.00	2.8
210203	ҮОМШӨ ний даатгал	318,400.00	30,240.00	288,160.00	9.5
210204	Ажилгүйдлийн даатгал	7,579,600.00	7,560.00	7,572,040.00	0.1
210205	Эрүүл мэндийн даатгал	61,994,200.00	29,831,038.71	32,163,161.29	48.1
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</u>	262,859,700.00	138,152,885.31	124,706,814.69	52.5
210301	Гэрэл цахилгаан	48,750,000.00	41,273,318.00	7,476,682.00	84.6
210302	Түлш, халаалт	67,609,700.00	67,907,356.31	(297,656.31)	100.4
210303	Цэвэр, бохир ус	19,500,000.00	13,972,211.00	5,527,789.00	71.6
210304	Байрны түрээс	127,000,000.00	15,000,000.00	112,000,000.00	11.8
2104	<u>Хангамж, бараа материалын зардал</u>	47,307,100.00	43,943,850.00	3,363,250.00	92.8
210401	Бичиг хэрэг	4,568,400.00	4,565,555.00	2,845.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	4,492,700.00	4,046,048.00	446,652.00	90.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	10,256,700.00	8,692,897.00	1,563,803.00	84.7
210404	Ном, хэвлэл	2,551,900.00	2,482,150.00	69,750.00	97.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,776,000.00	12,776,000.00	0,00	100.0
210406	БҮТЭЗҮЙЛС	12,661,400.00	11,381,200.00	1,280,200.00	89.8
2105	<u>Нормативт зардал</u>	77,581,700.00	39,822,275.00	37,759,425.00	51.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,123,000.00	2,122,100.00	900.00	99.9
210502	Хоол хүнс	74,605,100.00	37,071,175.00	37,533,925.00	49.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	853,600.00	629,000.00	224,600.00	73.6
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>	39,255,900.00	37,398,500.00	1,857,400.00	95.2
210601	Багаж, техник хэрэгсэл	17,556,300.00	16,073,500.00	1,482,800.00	91.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,199,600.00	825,000.00	374,600.00	68.7
210604	Урсгал засвар	20,500,000.00	20,500,000.00	0,00	100.0
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u>	118,798,100.00	113,985,780.00	4,812,320.00	95.9
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,959,300.00	90,470,680.00	4,488,620.00	95.2

Монгол Улсын консерваторийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	15,000,000.00	15,000,000.00	0,00	100.0
210803	Тээврийн хэрэгслийн татвар	398,800.00	143,100.00	255,700.00	35.8
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,440,000.00	8,372,000.00	68,000.00	99.1
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал</u>	34,830,000.00	31,153,160.00	3,676,840.00	89.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,510,000.00	1,833,450.00	3,676,550.00	33.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,320,000.00	29,319,710.00	290.00	100.0
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	470,991,300.00	229,917,900.00	241,073,400.00	48.8
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг</u>	470,991,300.00	229,917,900.00	241,073,400.00	48.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,655,900.00	10,380,200.00	23,275,700.00	30.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	429,335,400.00	214,667,700.00	214,667,700.00	50.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	4,870,000.00	3,130,000.00	60.8
1	<u>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</u>	5,042,849,000.00	4,068,627,816.04	728,781,483.96	84.8
1200041	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>	386,472,000.00	228,357,420.00	58,114,580.00	59.0
1200041_1	Үндсэн үйл ажиллагааны орлого	386,472,000.00	228,357,420.00	158,114,580.00	59.0
1200042	<u>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>	22,500,000.00	25,792,090.00	(3,292,090.00)	114.6
1200042_1	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	22,500,000.00	25,792,090.00	(3,292,090.00)	114.6
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	4,633,877,000.00	3,814,478,306.04	819,398,963.96	98.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,633,877,000.00	3,814,478,306.04	819,398,963.96	98.7
3101	<u>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</u>	-	17,600.00	(17,600.00)	-
900	<u>АЖИЛЛАГСДЫН ТОО</u>	245	245		100.0
9001	Удирдах ажилтан	12	12	-	100.0
9002	Гүйцэтгэх ажилтан	197	171	-	100.0
9003	Үйлчлэх ажилтан	36	36	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөлөгөө	Гүйцэтгэл
I	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>		6,218,500.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</u>		6,218,500.00
21	<u>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</u>		5,260,500.00
210	<u>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>		5,000,000.00
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл суутгал</u>		260,000.00
210103	<u>Унаа хоолны нэмэгдэл</u>		260,000.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u>		5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,000,000.00
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>		900,000.00
39	<u>Бусад урсгал шилжүүлэг</u>		900,000.00
39200	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		900,000.00
213503	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		58,500.00
1	<u>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</u>		6,218,000.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>		6,218,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,218,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,000,000.00
131103	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		900,000.00
131104	Нэмэлт санхүүжилт		260,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		58,500.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Консерваторийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Пүрэвхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөх, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдал, бараа материалын зарцуулалт болон холбогдох заавар, журам, шийдвэрийг дагаж мөрдөх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн захирал Ж.Оюунбилэг аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Д.Сайнбаяр, гэрээт аудитор Я.Золзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аккурэйт финанс Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь тогтвортой хөгжих нөхцөлийг хангасан Зүүн хойд Азийн тэргүүлэх Консерваториудын нэг болоход оршино.

Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын Консерватори нь Монгол Улсын мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд нийцсэн бүрэн дунд, мэргэжлийн, бакалавр, магистр, докторын боловсролтой чадварлаг мэргэжилтэн бэлтгэх үндсэн чиг үүрэгтэй.
- Монгол Улсын урлагийн салбарын хөгжил дэвшилд чиглэсэн эрдэм мэдлэг, соёлыг түгээх, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох,
- Шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ уран бүтээл, шинэ мэдлэг бүтээж, сургалт судалгаанд нэвтрүүлэх, инновацын бодлого хэрэгжүүлэх,
- Үндэсний сэтгэлгээ, өв санг бэхжүүлэх хүрээнд Монголын урлаг судлал, дэлхийн урлагийн өв сангаас гүнзгийрүүлэн судалж, эзэмших хүрээнд “Зэрэгцүүлсэн болон харьцуулсан урлаг судлал”-ыг хөгжүүлэх,
- Монгол Улсын урлагын салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, урт богино хугацааны сургалтыг чанартай гүйцэтгэж, хүний нөөцийн бодлого боловсруулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд:

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монгол Улсын Консерватори нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Монгол Улсын Консерваторийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Монгол Улсын Консерваторийн 2019 оны жилийн эцэс болон 2020 оны эхний 6 сарын байдлаарх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар дотоод хяналт шалгалт хийж акт, албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Монгол Улсын Консерваторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,501,107.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,011.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь болон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 5,447,258.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 54,472.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцов.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Улсын Консерваторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 332,597.9 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,588.5	2,606.1	17.6
Авлага	-	904.0	904.0
Бараа материал	168,101.5	222,065.4	53,964.4
Үндсэн хөрөнгө	11,255,814.2	10,868,330.8	(387,483.4)
Нийт хөрөнгө	11,426,504.3	11,093,906.4	(332,597.9)
Өр төлбөр	671.4	-	(671.4)

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,425,832.8	11,093,906.4	(331,926.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,426,504.3	11,093,906.4	(332,597.9)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,606.1 мянган төгрөг болж 17.6 мянган төгрөгөөр өссөн нь жижиг мөнгөн сан оны эцэст үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 904.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь харилцагч байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 222,065.4 мянган төгрөг болж 53,963.8 мянган төгрөгөөр өссөн нь 55,142.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 43,361.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, хандиваар хичээл практикийн материал 39,904.5 мянган төгрөг, сурах бичиг 2,278.9 мянган төгрөгийн орлого авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,868,330.8 мянган төгрөг болж 387,483.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 28,870.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном, бусад хөрөнгө, хандиваар 7,929.3 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж, тавилга, үнэ төлбөргүйгээр 31,793.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн хүлээн авч 68,593.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант жилд тооцсон 456,076.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Элэгдлээ нөхсөн 40,320.0 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны 763 тоот шийдвэрээр акталсан байна.

Өглөг дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд 671.4 мянган төгрөгийн өр төлбөр байсныг барагдуулснаас шалтгаалжээ.

Монгол Улсын Консерваторийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 195,150.6 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 195,150.6 мянган төгрөгийн орлого байна. Туслах үйл ажиллагааны санхүүжилт 3,189.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 27,169.1 мянган төгрөг, урсгал санхүүжилтийн орлого 461,974.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөр 179,863.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 179,786.3 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 179,786.3 мянган төгрөгөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 44,949.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 61,694.1 мянган төгрөгөөр өсөж, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 200,089.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 165,520.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,653.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 9,908.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 918.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,279,716.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,279,716.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 236,867.4 мянган төгрөгөөр бууруулж 5,042,849.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тус байгууллага нь багш ажилчдын цалинг шинэчлэн тогтоож, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад

гэрээгээр буюу цагийн багшаар ажиллаж байгаа ажиллагсдыг үндсэн орон тоонд оруулж төлөвлөөгүйгээс цалин, нийгмийн даатгалын зардал 261,257.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35,000.0 мянган төгрөг, томилолт, зочны зардал 470.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 5,476.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 15,170.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна. Харин хангамж, бараа материалын зардал 14,201.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 9,499.2 мянган төгрөг, нормативт зардал 15,274.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 41,531.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төсөлд 5,279,716.4 мянган төгрөгөөр санал хүргүүлснийг 236,867.4 мянган төгрөгөөр бууруулж, 5,042,849.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос 662,348.6 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,380,500.4 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, бусад орлогоор 254,149.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 4,634,649.8 мянган төгрөгөөс 4,068,610.2 мянган төгрөгийг зарцуулж, 17.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл үлдэж, 566,022.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,068,610.2 мянган төгрөг буюу 80.7 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 351,092.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 205,896.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 124,706.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 3,363.2 мянган төгрөг, нормативт зардлыг 37,759.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4,812.3 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлыг 3,676.8 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 6,218.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, унаа хоолны зардалд 260.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөрт 5,000.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 900.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 58.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 158 мэдээллээс хугацаандаа оруулсан 158 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,933.9 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсний хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	1,933.9	4	1,933.9	-	-	100.0
Нийт дүн	4	1,933.9	4	1,933.9	-	-	100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,593.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 33,593.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай тайлагнаагүй залруулах асуудал байгаагүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 33,593.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж нөхцөл хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авалт, харилцагчтай холбоотой 277,342.7 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 83 удаагийн худалдан авалттай холбоотой 32,547.1 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын шаардлага хангагдахгүй байх, улмаар төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтыг e-barimt төлбөрийн цахим системд баталгаажуулж байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 5 дахь заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал:13-р зүйлийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал, Татварын ерөнхий хуулийн 28-р зүйлийн 28.5.”дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх.” гэсэн заалтуудад нийцүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн журнал, жижиг мөнгөн сангийн тайлангаас тээвэр шатахууны зардлын тооцооллыг түүвэрлэн шалган үзэхэд 1,046.0 мянган төгрөгийн төлбөр тооцоог цаг тухай бүрд нь хянаж баталгаажуулаагүй байна. Үүнээс зайлшгүй ажлын шаардлага гарсан үед машин хөлслөхөд гарсан зардал 471.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна “гэсэн заалт, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал алдаатай хөтлөгдөж, тайлагнагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид төлбөрийн и баримтгүй гүйлгээ гаргахгүй байх, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөж, хяналт тавин ажиллана.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналт, үнэлгээ хариуцсан ажилтан нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" 4.4 "Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрэй 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна." гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Санхүү, өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, хадгалалт хамгаалалт, худалдан авалт, зарцуулалт, ашиглатанд тавих хяналт сулрах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт үнэлгээний ажилтан байгууллагын хөрөнгө, санхүүгийн байдалд шалгалт хийх жилийн төлөвлөгөө гарган, шалгалтыг үр дүнтэй хийж, зөрчилтэй асуудалд шаардлага тавьж, зөвлөмж өгч хэвших, хэрэгжилтийг бүрэн хэвшүүлж ажиллах, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дүрэм батлах тухай" 4.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Монгол Улсын консерваторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/157/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Улсын консерватори		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Тайлант онд худалдан авалт, харилцагчтай холбоотой 277,342.7 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 83 удаагийн худалдан авалттай холбоотой 32,547.1 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байгаа нь үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна	32,547.1	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Пүрэвхүү Д.Болормаа
2	Мөнгөн хөрөнгийн журнал, жижиг мөнгөн сангийн тайлангаас тээвэр шатахууны зардлын тооцооллыг түүвэрлэн шалган үзэхэд 1,046.0 мянган төгрөгийн төлбөр тооцоог цаг тухай бүрд нь хянаж баталгаажуулаагүй байна. Үүнээс зайлшгүй ажлын шаардлага гарсан үед машин хөлслөхөд гарсан зардал 471.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй байна Энэ нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.	1,046.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Пүрэвхүү Д.Болормаа
3	Байгууллагын дотоод хяналт, үнэлгээ хариуцсан ажилтан нь Монгол Улсын засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" 4.4 "Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрэй 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна." гэсэнтэй нийцэхгүй байна	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Пүрэвхүү Д.Болормаа
ДҮН		33,593.1			